

## УЛС ТӨРИЙН НАМЫН ГИШҮҮНЧЛЭЛИЙН АСУУДЛААР М.ДЮВЕРЖИЙН ҮЗЛИЙГ ЭРГЭН ҮЗЭХҮЙД

**Г.Цэнд-Аюуш**

*МУИС-ийн Улстөр судлалын тэнхмийн дэд профессор*

**Н.Ариунаа**

*МУИС, Улс төр судлалын тэнхимийн докторант*

**Түлхүүр үг:** олон түмний ба боловсон хүчний нам, гишүүнчлэлийн индекс, нотабал, намын машин.

**Хураангуй:** Францын улс төр судлаач М.Дювержийн улс төрийн намын талаарх үзэл баримтлалыг манай улс төр судлаачид, магадгүй зарим улс төрч эрхэмүүд уншиж танилцсан нь мэдээж. Тэрбээр улс төрийн намын сонгодог ангилалыг, төдийгүй намын бүрэлц, чиг үүрэг, гишүүнчлэлийн гээд олон асуудлыг Америк,Европоос өгсүүлээд Австрали тив хүртэлх улс орнуудын улс төрийн намуудын онцлогын талаар хийсэн олон жил жилийн судалгаандаа тулгуурлан өөрийн үзэл баримтлалаа дэвшүүлж олны хүртээл болгосон дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн улс төрийн “төлөө” амьдралаа зориулсан нэртэй улс төр судлаач, нийгмийн зүтгэлтэн байв. Аль нэг нам бодит байдал дээр олны итгэл даах чадвартай байна гэдгийг тандахад төдийгүй маргааш сонгууль боллоо гэхэд аль нам, хэний төлөө саналаа өгөх вэ? гэсэн сонгогчдын эргэлзээт сэтгэлгээг нэг тийш болгоход түүний дэвшүүлсэн үзэл санаа үнэтэй бөгөөд өнөө хэр үнэ цэнэ нь алдраагүй гэдэгтэй маргах судлаач хүн гарахгүй болов уу.

Орчин үеийн улс төрийн ном зохиолд хамгийн илүүтэйгээр хүлээн зөвшөөрөгдсөн М.Дювержийн намын ангилал бол “боловсон хүчний”, “олон түмний” ба “хагас олон түмний” гэж авч үзсэн явдал. Боловсон хүчний ба олон түмний намуудын ялгаа нь тэдний хамрах хүрээ, гишүүдийн тоонд бус, гадаад ялгааны тухайд биш, харин **бүтцийн тухай өгүүлж байгаад**<sup>5</sup> оршино. Энэ бүтцэд **жинхэнэ оролцон тоглогч цөм нь намын гишүүд** байдаг. Яагаад намд гишүүд, дэмжигчид хэрэгтэй байдаг вэ? Гишүүдтэй байна гэдэг нь нам оршин байх улс төрийн болон санхүүгийн талаасаа үйл ажиллагааных нь тулгуур хэрэгцээ болж ирсэн түүхтэй. Асуудлыг ингэж авч үзэх арга зүйн рационал хандлага улс төр судлаачдын хувьд өнөө хэр хэвээр байгааг тэмдэглэх нь зүйн хэрэг болой. Энэ нь хэд хэдэн шалгаант учир холбогдлоор тайлбарлагдана. Үүнд: 1. Намын гишүүд, дэмжигчид чухамдаа намын нийгмийн бааз, үйл ажиллагааны эх суурь болдог. Гишүүдгүй намыг сурагчгүй багштай зүйрлэж болно.

2. Гишүүд нь намд боловсон хүчний нөөц, чадварлаг нэр дэвшигчийг тодруулах үндэс, нөхцлийг бүрдүүлнэ.
3. Гишүүд, дэмжигчдийн дэмжлэгээр сонгуулийн кампаний үеэр илүү амжилт олох магадлал өндөр байдаг.
4. Тухайн намын үзэл суртал, мөрийн хөтөлбөр, платформын дэмжлэг сайшаагдана.
5. Сонгогч олон түмэнтэй намын үйл ажиллагааг холбогч гүүр болж өгнө.
6. Намын гишүүдийн үзэл санаа, идэвх, оролцоо, хариуцлага дээшлэхийн хэрээр тэр нь материаллаг хүч болж хувирна.

---

<sup>5</sup>Современная буржуазная политическая наука: проблемы государства и демократии. М., 1982. с.217

7. Намын легитим чанар баталгаажна.

8. Гишүүний татвар, хандиваас орлогын нэгэх үүсвэр бий болдог г.м.

Тэгвэл эргээд намын гишүүн байх хэрэгцээний асуудал гарч ирнэ. Энэ нь:

1. Улс төрийн үзэл бодол, хүсэл зоригоо намд нэгдэж илэрхийлэх, дамжуулах.
2. Өрнөж буй улс төр, нийгмийн үйл явцын талаар илүү их ойлголт, мэдээлэл олж авч бусадтай санал бодлоо солилцох /сонин, сэтгүүл, сургалт, хурал, цуглаан, ярилцлага г.м / боллоцоо нэмэгдэнэ.
3. Улс төрийн нийгэмшилд хамрагдаж улс төрийн идэвх, оролцоо дээшлэнэ.
4. Журмын олон нөхөдтэй болж сонирхлоо илэрхийлэх, нэгтгэх зэрэг сэтгэл зүйн шинэлэг уур амьсгал давамгайлах болно.
5. Намаар дамжиж төлөвшин аливаа нам, төрийн албан тушаалд сонгогдох, томилогдох боломж нээлттэй байна.
6. Нам өөрөө сонгогчдын хүсэл тэмүүлэл, олон түмний сонирхолд баримжаалсан бодлогын нам болж төлөвшихөд их нөлөөлнө.

“Олон түмний нам гишүүдийн тооны хэмжээгээр амжилт олдог бол боловсон хүчний намууд чадвартай нэр дэвшигчдийг шилж сонгох замаар мөн дэвшүүлж буй **бодлого,хөтөлбөрөөрөө** амжилт олдог. Боловсон хүчний намууд хатуу гишүүнчлэлгүйг”<sup>6</sup>М.Дюверже тэмдэглэсэн байдаг. Олон түмний намын алтан үе нь XX зууны 30-70-аад онууд байв. Олон түмний намуудын үүсэл хязгаарлагдмал сонгуулийг бүх нийтийн оролцоотой сонгуулиар сольсон цаг үетэй давхацсан гэж тэрбээр нотолдог. “Хязгаарлалттай сонгуулийн дэглэмийн үед (XIX зууны сүүлээс эхлэлтэй дүрмээр - Г.Ц )намууд боловсон хүчний намын хэлбэрийг голлож байсан нь зүйн хэрэг, **тэр үед олон түмэн улс төрийн нөлөөллийг төдийлөн эзэмшээгүй байсан тул намуудын өмнө олон түмнийг татаж оролцуулах зорилт гол биш байв.** Нөгөө талаар хөрөнгөтнүүд сонгуулийг санхүүжүүлэх явдлыг зүй ёсны хэрэг гэж үзэж байжээ”<sup>7</sup>.

Аливаа нам нь олон түмний дэмжлэгийг авахын зэрэгцээ сонгуульд бэлтгэх ажлыг зохион байгуулах, нэр дэвшигчдийг шилж сонгох,нэр дэвшигчдийн нэр хүнд, туршлага, чадварыг дээшлүүлэх, намын үйл ажиллагааг болон сонгуулийн кампанийг санхүүжүүлэх технологийг боловсронгуй болгох, нийгэмд тухайн намын байр суурийг легитимжүүлэх зэрэг жинхэнэ улс төрийн системд **ажиллагч**гэдэг утгаар нь “**боловсон хүчний нам**” хэмээн нэрийджээ. Боловсон хүчний нам бол улс төр судлаачдын үздэгээр **бодлогын намын ойлголтод** тохирч байгаа юм.Үүнтэй холбогдуулж жишээ татахад сонгуульд бэлтгэх болон депутатуудтай тогтоосон харилцаагаа хадгалах зорилгоор **нотабалуудыг**(XIV-XV зууны үед францын хааны зарлигаар мөнгө санхүү, засаг захиргааны г.м чухал асуудлыг хэлэлцдэг **онцгой хуралдааны гишүүдийг** хэлж байна. Тэр гишүүдэд язгуур угсаа, эрх ямба хамаатахгүй, **гагцхүү эрдэм мэдлэг, чадвар чансаа гол үзүүлэлт** нь болдог-Г.Ц )**нэгдүүлэх** тухай М.Дюверже өгүүлсэн байдаг. М.Дюверже нотаблийн хэд хэдэн чанар чансааг ялгаж үзжээ. **Нэгд**, өөрийн нэр алдраараа депутатад нэр дэвшигчдийн нэр хүндийг өсгөж, тэдний төлөө өгөх саналыг олж авахад тусалдаг нотабалууд. **Хоёрт**, сонгуулийн кампанийг сайн зохион байгуулахчадамжтай нотабал. **Эцэст нь**, санхүүчдийн нотабал орно. Тийм ч учраас нэр алдар, зохион байгуулах ур чадвар, тэдний олон түмэнд танигдсан нөлөөллийн хамрах хүрээний байдал зэрэг нь намын ажлыг идэвхжүүлэх, олон түмнийг улс төрд татан оролцуулахад чухал хүчин зүйл болдог байна. Үүнтэй холбогдуулж дашрамд дурдахад М.Вебер, М.Острогорский, Р.Михельс, хожим М.Дюверже нарын зохиол бүтээлүүдэд **намын машин, намын бюрократ** гэсэн томъёоллууд тааралддаг. Улс төрийн намын аппаратад тэдний ( намын машин, бюрократын-Г.Ц )бодит засаглал албан бус шинжтэй хэдий ч тэднээс намын бүх ажил хэрэг

<sup>6</sup>Современная буржуазная политическая наука: проблемы государства и демократии. М., 1982. с.218.

<sup>7</sup>Мөн тэнд. с 219.

хамаардаг байна. Мэргэшлийн улс төрчид, нэр нөлөө бүхий улс төрийн ажилтнууд намын дотоод амьдралын асуудлыг зохицуулах, сонгуульд нэр дэвшигчдийг сонгон шалгаруулах, сонгуулийн кампанийг зохион байгуулах, төрийн ба улс төрийн албан тушаалтныг хуваарилах г.м асуудлыг тэд үндсэндээ шийддэг байна. Тэр “**машинууд**” парламентын гишүүд, намын лидерүүдээс ч хараат бус, хүчтэй давуу эрхтэй байдаг байна.

Тухайн үедээ Соц-декүүд “улс төрийн намууд намын бюрократуудын гарт орж олзлогдлоо” гэж шүүмжилж байв. Өнөөгийн бюрократ ёсны өнцгөөс үзвэл тийм мэргэжлийн өндөр боловсрол, туршлагатай, ажлаа сайн мэддэг, хээл хахуульд автдаггүй чин шударга хүмүүс намд төдийгүй төрд үгүйлэгдэж байгааг онцолбол зохино.

М.Дюверже намын үйл ажиллагаан дахь “оролцооны дүрсүүдийг” ангилж үзсэн байдаг.

Боловсон хүчний буюу формал (албан ёсны-Г.Ц ) гишүүнчлэлгүй намуудад тэрбээр гурван “**оролцооны хүрээг**” ялгаж гаргасан. Хамгийн өргөн хүрээг **намын төлөө саналаа өгдөг сонгогчид** бүрдүүлдэг. Мөн энэ хүрээнд “**талархагчдын**” хүрээг багтаасан байна. Нөгөө нь **намын идэвхтнүүдийг нэгтгэсэн дотоод хүрээ** байдаг.

М.Дюверже бичихдээ: “эдгээр янз бүрийн оролцооны хүрээний хоорондын харилцааг тодорхойлох нь намын тулгуур асуудлын нэг”<sup>8</sup> гэжээ. Дээрх харилцааг шинжилсэний үндсэн дээр намын мөн чанарыг тодорхойлох боломж бүрдэнэ. **Дотоод хүрээ гадаад хүрээнд түлхээс өгч хөтөлдөг.**

Боловсон хүчний намуудын хувьд сонгогчдын тоо намын хүчтэй эсхүл сул чанарыг тодорхойлох боломжийг өгдөг гол үзүүлэлт. Намын **удирдах байгууллагын бүрэлдэхүүнийг** сонгогчдын социал бүрэлдэхүүнтэй харьцуулж аль нэг намын байгууллагын **ардчилалдсан төвшний** талаар дүгнэлт гаргаж болно. Мөн олон түмний намын сонгогчдын тухай мэдээ, мэдээллийг судалгааны үндсэн гаргах өргөн боломж бий. М.Дюверже “**гишүүнчлэлийн индекс**”-ийг (намын гишүүдийн тоо ба сонгогчдын тооны хоорондын харьцааг-Г.Ц ) ашиглахыг санал болгосон байдаг. Улс төр судлаачдын үзэж буйгаар ижил төрлийн намуудын (түүний төлөвшлийн янз бүрийн үеүдийн, газар зүйн төрөл бүрийн байршил дахь дүүргийн, олон янзын социал болон насны бүлгүүдэд г.м) “**гишүүнчлэлийн индекс**” харьцуулалт хийх нь сонирхол татсан асуудал болж байна.

М.Дювержийн “дэмжигч” гэсэн түвэгтэй ойлголт тааралдана. Сонгогч өөрийн саналаа намд өгч болохоос гадна тэр нь үүгээр хязгаарлагдахгүй. Сонгогч өөрийнх нь санаа зориг намынхтай нийцэж байгаа эсэхээ мөн улс төрийн эрхэмлэл, чин хүслээ янз бүрийн төвшинд, төрөл бүрийн хэлбэрээр харуулж болно. Саналаа өгч нууцаа нээсэн сонгогч нар “**дэмжигчдэд**” тооцогдоно. Нэлээдгүй “**дэмжигчид**” намд ач тустай үйлдэл хийдэг: намын хэвлэл тогтмол захиалж унших, жагсаал, цуглаан, улс төрийн хурал, ухуулгын ажилд оролцох, мөнгөн хандив өгөх г.м. Гэхдээ “**дэмжигч**” бол **намын жинхэнэ гишүүн биш**. М.Дювержийн үзсэнээр формал гишүүнчлэлгүй, боловсон хүчний намуудад өөрсдийн санаа зориг нь намынхтай нийцэж байгаагаа нээлттэй мэдэгдсэн хэн бүхэн (хороодоос бусад буюу намын идэвхтнийг хороодын гишүүн гэсэн байдаг-Г.Ц) “**дэмжигчдийн**” хүрээнд хамаарагдана<sup>9</sup>. (Энэ зүйл МУ-ын улс төрийн намын хуулийн шинэчилсэн төслийн 3.2 заалттай нийцэхгүй байгаа юм- Г.Ц )

Дараагийн хүрээнийхэн бол намын төлөө туйлбартай саналаа өгдөг **жинхэнэ гишүүд**. (МУ-ын улс төрийн намын хуулийн шинэчилсэн төслийн 3.1 заалттай дүйж байгаа юм- Г.Ц )

Намд гишүүнээр элсэж байгаа хэн бүхэн намын сахилгыг сахиж, намын үзэл номлолыг сурталчилж байх үүргийг журамласан баримт бичгийг бөглөж гарын үсгээ зурсан байх ба тийм

<sup>8</sup>Современная буржуазная политическая наука: проблемы государства и демократии. М., 1982. с.220.

<sup>9</sup>Современная буржуазная политическая наука: проблемы государства и демократии. М., 1982. с.222

журам аль ч намын дүрэмд байдаг. М.Дюверже энэ баримт бичиг зайлшгүй байх нь хоёр талтай гэж үзсэн байдаг. **Нэгд**, намд элсэгчдэд энэ баримт бичиг сэтгэл зүйн маш хүчтэй нөлөөлөл үзүүлдэг байна. “Манай соёл иргэншлийн хүрээнд бичгээр үүрэг хүлээх нь хэл амаар хүлээхээс илүү хүчтэй, гарын үсэг бүрдүүлдэг системд зарим төрлийн зан үйлд ид шидийн шинж чанарыг олж байсан”<sup>10</sup> байна. **Хоёрт**, Тийм **баримт бичиг** ямар нэг байдлаар намд элсэгчдийн тодорхой биеийн байцаалт (анкет-Г.Ц) болдог байна.

М.Дюверже гишүүнчлэлийн **нээлттэй ба дүрэмт** гэсэн хоёр хэв маягыг ялгаж үзсэн байдаг. Нээлттэй гишүүнчлэл зохих баримт бичгүүдэд гарын үсэг зурахад л хангалттай. Дүрэмт гишүүнчлэлд намд элсэх хүсэлтээ илтгэсэн өргөдөл өгөх шаардлагатай бөгөөд тэр нь намын аль нэг байгууллагаар хэлэлцэгддэг. Зарим тохиолдолд намд элсэгчдэд намын гишүүний батламж (рекомендаци-Г.Ц) гаргах шаардлага тавигддаг. (МУ-ын улс төрийн намын хуулийн шинэчилсэн төслийн 4.3 заалттай дүйцэж байгаа юм- Г.Ц)

Дараагийн багтдагхүрээнд **идэвхтнүүд** багтдаг. Идэвхтнүүд намын бааз суурь, цөм нь болдог. **Идэвхтнүүд сонгогдсон болон томилогдсон гүйцэтгэгчид мөн ба тэдэнгүйгээр намын аливаа үйл ажиллагаа гүйцэлдэх боломжгүй.** Боловсон хүчний намд идэвхтнүүдийг Дюверже **хороодын гишүүд** гэж нэрлэсэн байдаг. (МУ-ын улс төрийн намын хуулийн шинэчилсэн төслийн 3.3 заалттай дүйж байгаа юм- Г.Ц)

Олон түмний намуудын хувьд **“идэвхтнүүдийн индекс”**-ийг тэрбээр идэвхтнүүдийн ба намын гишүүдийн тооны харьцаа байна гэж үзсэн.Түүний үзсэнээр “гишүүнчлэлийн индекс”-ийг “Идэвхтнүүдийн индекс”-тэй харьцуулах нь улс төрийн намын бодит хүч чадамжийн илүү бүрэн дүүрэн дүр зураг тодруулах боломж олгодог байна. Тийм харьцуулалт хийхэд шаардлагатай баримт мэдээ,мэдээлэл хэрэгтэй болох нь хэн бүхэнд ойлгомжтой.

Намын гишүүнчлэлийн талаарх М.Дювержийн нийтлэг загварыг гишүүний үүрэг, хариуцлагын талаас нь:

1. Намын кадр боловсон хүчин буюу сонгуульт гишүүн (сонгогдсон албан тушаалтан буюу намд алба хашдаг гишүүн)
2. Идэвхтэй гишүүд буюу намын жинхэнэ гишүүд (бодлого боловсруулахаас өгсүүлээд намын бодлого, зорилгыг олон түмэн хүргэх, тэднийг манлайлан татах, намын рейтингийг өсгөхөд оролцдог идэвхтэй хэсэг)
3. Дэмжигчид (намыг талархан дэмжиж,тусалдаг хүмүүс) гэж ангилсан байдаг.

#### Дүгнэлт

1. Нийгмийн амьралыг хамарсан хувьсал өөрчлөлттэй (олон нам бий болсон, сонгогчдын улс төрийн мэдлэг,боловсрол харьцангуй дээшилсэн,мэдээлэл харилцаа өргөжсөн, хүн амын бүтцэд өөрчлөлт орсон, олон ургальч үзэл дэлгэрсэн, хүмүүсийн индивидуал чанар нэмэгдсэн зэрэг) холбогдож олон түмний намууд олон зүйл амласан сүржин уриалга, хөтөлбөрийг болон нийт хүн амыг түшсэн урьдын өнгө төрхөө гээж байна.
2. Намын хатуу гишүүнчлэлээс татгалзах шаардлага бий болсонтой холбогдож (намуудын дотоод бүтэц, зохион байгуулалтанд хувьсал гарч эхлэв)гишүүнчлэлийн альтернатив хувилбарыг илүүд үзэх боллоо.
3. Улс төрийн намууд бодлогын нам болж төлөвших хандлага давамгайлах болсон.
4. Улс төрийн намууд олон түмэнд хандсан сонгуулийн илүү үр дүнтэй кампанит ажил, маркетингийн бодлогод илүүтэй анхаарах болсон.
5. Намууд гишүүд, дэмжигчидтэйгээ байнгын эргэх холбоонд үйл ажиллагаагаа шинэлэг хэлбэрээр зохион байгуулах (боловсон хүчний бас бодлогын нам байх утгаараа) хэрэгцээ шаардлага зүй ёсоор гарч байна.

<sup>10</sup>Мөн тэнд. с. 223.

Чухамдаа ингэж байж намын ардчилал хөгжинө, тэр хэрээр намын төлөвшил баттай үргэлжлэх болно.

**Резюме:** Книга Мориса Дюверже

"Политические партии"/1951/известна каждому профессиональному политологу.

Это профессиональное исследование о политической партии будет исключительно полезно и каждому избирателю.

Во всяком случае его основные положения необходимо знать, чтобы адекватно оценивать состояние партийной системы в Монголии, наблюдающиеся тенденции и прогнозировать перспективы развития. И в конце концов, чтобы сделать разумный выбор между партиями в день голосования, понимая, чем та или иная партия является на самом деле. Формальный механизм вступления в партию имеет только в массовых партиях. Он включает написание заявления - одинакового для всех - и ежегодную уплату членских взносов. В кадровых партиях нет ничего, ни другого, ту да вступают без всяких официальных процедур, а систему членских взносов заменяют там эпизодические пожертвования.

Ном зүй:

1. Антология мировой политической мысли (Пяти томах) М., 1997.
2. Дюверже. М. Политические партии. М., 2000.
3. Острогорский. М. Демократия и политические партии. Глава-6 М., 1930.
4. Михельс. Р. Социология политической партии в условиях современной демократии. М., 1911
5. Вебер. М. Улс төр бол мэргэшил мөн. Шинжлэх ухаан бол мэргэшил мөн. УБ., 2000
6. Современная буржуазная политическая наука: проблемы государства и демократии. М., 1982.
7. Г. Цэнд-Аюуш. Өрнийн улс төрийн сэтгэлгээний түүхэн тойм (Дэд дэвтэр) УБ., 2016